



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 22 өдөр

Дугаар A/78

Улаанбаатар хот

### Сануулах арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчтэй хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, “Хяналт шалгалтын журам”-ын 13 дугаар зүйлийн 13.1.1.12, 13.1.1.13, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.1.1 дахь заалт, Хяналт, шалгалтын дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн “Гаули УЦК” ХХК-ийн ажилтны буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан үнэт цаасны арилжааны хэлцэл цуцлагдсан, үнэт цаасны арилжаанд нэвтрэх эрхийг бусдад шилжүүлж, ажлын хариуцлага алдсан зөрчил гаргасан байх тул сануулах арга хэмжээ авсугай.
- “Гаули УЦК” ХХК-ийн гаргасан зөрчлийг арилгуулах талаар холбогдох арга хэмжээг авч, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар /А.Мөнхбаясгалан/-т даалгасугай.
- Цаашид үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Монгол Улсын хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллахыг, алдааг давтан гаргасан тохиолдолд шат дараалсан арга хэмжээ авахыг “Гаули УЦК” ХХК-ийн захирал /Хан Гю Бун/-д хатуу анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ X.АЛТАЙ



000274